

**Гадаадын зээл, тусламж, Засгийн газраас гадаад зах зээлд гаргасан бонд, МУХС-гийн хөрөнгөөр 2008-2013 оны 9 дүгээр сар хүртэлх хугацаанд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын чанартай төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн**



**Зээл, тусламжийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтэд нэгдсэн бодлого үгүйлэгдэж байна**

<b>Агуулга</b>	Товчилсон үгийн жагсаалт.....	4
<b>Тайланг бэлтгэсэн:</b>	Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл .....	5
<b>ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар</b>	<b>Аудитын явцад гарсан хүндрэл бэрхшээл</b>	6
<i>Дарга С.Төмөрхүү</i>	<b>Бүлэг 1: Чингис бондын хөрөнгөөр санхүүжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна</b>	
<i>Аудитын менежер Г.Гүнжидмаа Д.Баттулга</i>	• Ерөнхий мэдээлэл.....	7
<i>Ахлах аудитор</i>	• "Чингис бондын хөрөнгөөр санхүүжих төсөл хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, үр ашгийн тооцоо бэлэн болоогүйгээс хэрэгжилт удаашралтай байна.....	8
<i>С.Сэрчхорол У.Баярмаа</i>	• Чингис бондын хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хөрөнгийн 59 хувь нь төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй байна....	10
<i>Ш.Энхтайван Б.Саруул</i>	• Төслийн нэгжийн үйл ажиллагааны зардлыг бондын хөрөнгөөс санхүүжүүлж байна.....	11
<i>Аудитор</i>	• Чингис бондын хөрөнгөөр шууд гэрээ байгуулан төсөл хөтөлбөрийг санхүүжүүлж байна.....	12
<i>Ц.Эрдэнэчулуун Ц.Цолмон</i>	• Хөгжлийн банкны өөрсдийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй төслийн талаар .....	13
	• "Чингис бонд" болон Хөгжлийн банкны өөрийн гаргасан бондын хүүгийн төлбөрт жил тутам 105.24 сая ам.доллар төлж байна.....	14
<b>2014 оны 6 дугаар сар</b>	• Дүгнэлт .....	15
<b>Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү. <a href="http://www.mnao.mn">www.mnao.mn</a></b>	• Зөвлөмж.....	15
	<b>Бүлэг 2: Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын ашиглалт, үр нөлөөг тооцох ажил хангалтгүй байна.</b>	
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	• Ерөнхий мэдээлэл Хөнгөлөлттэй зээлийн талаар.....	16
	Буцалтгүй тусламжийн талаар.....	16
<b>ХАЯГ:</b>	• Гадаадын зээл, тусламжийг зохицуулах нэгдсэн бодлого дутагдаж байна.....	17
<i>Үндэсний аудитын газар Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр Улаанбаатар хот 15160 Монгол улс</i>	• Судалгаанд хамрагдсан зээл тусламжийн хөрөнгийн дийлэнх хувь нь хөрөнгө оруулалтын чанартай байна.....	19
	• Зээл, тусламжийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй байна.....	21
	• Зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслийн бүртгэл зөрүүтэй, түүний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.....	22
	• Дүгнэлт.....	26
	• Зөвлөмж.....	26

**Бүлэг 3: Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнг тооцож баталгаажуулаагүй байна**

• Монгол Улсыг хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлээгүй байна.....	27
• Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008-2009 оны төсвийн зарлагын зарим зардлыг хэтрүүлсэн байна.....	28
• МУХС-гийн хөрөнгөөр худалдан авсан хүнсний улаан буудайн үлдэгдлийн тооцоо хийж баталгаажуулаагүй байна.....	28
• Дизель түлш, шатахууны тооцоо хийж өр, авлагын үлдэгдлийг эцэслэн баталгаажуулаагүй байна.....	31
• 2009 онд татан буугдсан МУХС-гийн дуусгалтын тайлан тэнцлийг гаргаж, өр авлагын тооцоо нийлж, хөрөнгийн үлдэгдлийг зохицуулах шийдвэр гараагүй байна.....	31
• Дүгнэлт.....	33
• Зөвлөмж.....	33
<b>Холбогдох байгууллагын санал</b>	34
<b>Ерөнхий аудиторын тушаал</b>	35
<b>Хавсралт</b>	36

## Товчилсон үгийн жагсаалт

<b>ААН</b>	Аж ахуйн нэгж
<b>АХБ</b>	Азийн хөгжлийн банк
<b>АНУ</b>	Америкийн Нэгдсэн Улс
<b>БНСУ</b>	Бүгд Найрамдах Солонгос Улс
<b>БОАЖЯ</b>	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
<b>БСШУЯ</b>	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
<b>ГЕГ</b>	Гаалийн ерөнхий газар
<b>ГЗТЗТХ</b>	Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль
<b>ГОУХАН</b>	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
<b>ГТХАН</b>	Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэг
<b>ДБ</b>	Дэлхийн банк
<b>ДНБ</b>	Дотоодын нийт бүтээгдэхүүн
<b>ДЭМБ</b>	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
<b>ЗГУАХ</b>	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
<b>ЗТБХАГ</b>	Зээл тусламжийн бодлого, хамтын ажиллагааны газар
<b>ЗТБХБЯ</b>	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам
<b>ММСС</b>	Монголын мянганы сорилтын сан
<b>МУЗН</b>	Монголын Улаан загалмайн нийгэмлэг
<b>НӨАТ</b>	Нэмэгдсэн өртгийн албан татвар
<b>НҮБ</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллага
<b>НҮБХАС</b>	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сан
<b>НҮБХС</b>	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан
<b>НХХЯ</b>	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
<b>ОБЕГ</b>	Онцгой байдлын ерөнхий газар
<b>ОУВС</b>	Олон улсын валютын сан
<b>ОУСБ</b>	Олон улсын санхүүгийн байгууллага
<b>ОУБ</b>	Олон улсын байгууллага
<b>ӨУХ</b>	Өрийн удирдлагын хэлтэс
<b>ӨЭМТ</b>	Өрхийн эрүүл мэндийн төв
<b>СБӨУГ</b>	Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газар
<b>ТЭДС</b>	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
<b>ТЕГ</b>	Татварын ерөнхий газар
<b>ТХБ</b>	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага
<b>ТХН</b>	Төсөл хэрэгжүүлэгч нэгж
<b>ТУХ</b>	Төслийн удирдах хороо
<b>ТЭЗҮ</b>	Техник эдийн засгийн үндэслэл
<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>ҮАГ</b>	Үндэсний аудитын газар
<b>ХАЁТ</b>	Хөгжлийн албан ёсны тусламж
<b>ХБ</b>	Хөгжлийн банк
<b>ХХААХҮЯ</b>	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
<b>ХХБ</b>	Худалдаа хөгжлийн банк
<b>ШХА</b>	Швейцарийн хөгжлийн агентлаг
<b>ЭЗХЯ</b>	Эдийн засгийн хөгжлийн яам
<b>ЭБЭХЯ</b>	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
<b>ЭХГ</b>	Эрчим хүчний газар
<b>ЭСЯ</b>	Элчин сайдын яам

## **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

## **Аудитын зорилт**

Аудитын зорилт нь хандивлагч улс, олон улсын байгууллагаас Монгол Улсын Засгийн газрын шугамаар үзүүлж буй хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтын ашиглалт, үр нөлөөт байдал, Засгийн газраас гадаадад гаргасан бондын болон МУХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнг шалган дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд чиглэгдсэн болно.

## **Хамарсан хүрээ**

Гадаадын зээл, тусламж, Засгийн газраас гадаадад гаргасан бонд, МУХС-гийн хөрөнгөөр 2008-2013 оны 9 дүгээр сар хүртэлх хугацаанд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын чанартай төсөл арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэгч нэгж, зээл, тусламжийн асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагын үйл ажиллагааг хамруулав.

## **Аудитын арга зүй, стандартын талаарх мэдэгдэл**

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газар хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээр, санамж бичиг, санхүүжилтийн гэрээ, хэлцлийн зорилттой харьцуулах,
- Сангийн яамны СБӨУГ, ӨУХ, төсөл хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллага, ТХН-ийн үйл ажиллагааны тайлантай танилцаж судлах, судалгаа, тоон мэдээлэл гаргуулах, холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцлага хийж, түүнд дүн шинжилгээ хийх,
- Зарим төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийн байдлыг газар дээр нь танилцах, зураг авалт хийх,
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Татварын ерөнхий газар, Гаалийн Ерөнхий газраас судалгаа тоон мэдээлэл авч судлах,
- Хөгжлийн банкны үйл ажиллагаа, Чингис бондоор санхүүжүүлсэн төсөл арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх төслийн нэгжийн үйл ажиллагаатай танилцах, мэдээ тайланд дүн шинжилгээ хийх.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

### ***Аудитын явцад гарсан хүндрэл бэрхшээл***

Сангийн яамны СБӨУГ аудитын зорилттой холбогдсон судалгаа, үр ашиг, үр нөлөөний тооцооллыг хийгээгүй, зарим төсвийн ерөнхийлөн захирагчдын төслийн нэгдсэн судалгаа хангалтгүй, төсөл хөтөлбөр нь хэрэгжиж дууссанаас төслийн хэрэгжилттэй холбоотой баримтууд олдохгүй байх зэргээс зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл хөтөлбөрт бүрэн хэмжээгээр аудит хийхэд хүндрэл гарлаа.

МУХС-гийн санхүүгийн баримт материал дутуу, хариуцсан мэргэжилтэн нь солигдож тухайн асуудлыг хариуцах хүнгүйгээс хаалтын тайлан тэнцэл гаргаагүй, архивын баримт материалаа үлдээгүйгээс аудит хийхэд хүндрэлтэй байлаа.



# Бүлэг 1

## Чингис бондын хөрөнгөөр санхүүжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна

### Ерөнхий мэдээлэл

- 1.1. УИХ-ын 2012 оны 52 дугаар тогтоолоор эдийн засгийн өсөлтийг хангах, урт хугацааны хөрөнгө оруулалт хийх, экспортыг дэмжих бодлогыг санхүүжүүлэх зорилгоор дунд, урт хугацааны 5.0 тэрбум ам.доллар хүртлэх Засгийн газрын үнэт цаасыг 2012-2014 онуудад үе шаттайгаар олон улсын зах зээлд арилжаалахыг зөвшөөрсөн ба уг хөрөнгийг нийгмийн халамжийн аливаа үйлчилгээ болон улсын төсвийн орлогын дутагдлыг нөхөхөөс бусад эрдэс баялаг, зам, тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо, барилга, банк санхүү, аж үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх эдийн засгийн үр ашиг бүхий томоохон төслүүдэд хөрөнгө оруулахад зарцуулахыг Засгийн газарт даалгажээ.
- 1.2. Энэхүү тогтоолын дагуу Засгийн газрын "Чингис бонд"-ыг олон улсын зах зээлд 5 жилийн хугацаатай жилийн 4.125 хувийн хүүтэй 500.0 сая ам.долларын, 10 жилийн хугацаатай жилийн 5.125 хувийн хүүтэй 1,000.0 сая ам.долларын бондыг тус тус арилжаалж, үүнээс 5.4 сая ам.долларыг бондыг арилжаалах үйл ажиллагааны зардалд гэрээний дагуу суутгуулж, 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Монгол банкин дахь Засгийн газрын бондын харилцах дансанд 1,494.6 сая ам.долларын орлого орсон байна.
- 1.3. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл 2012 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 28/20 дугаар зөвлөмжөөр доорх чиг үүргийг хэрэгжүүлэхийг Засгийн газарт зөвлөжээ. Үүнд:
  1. Засгийн газрын үнэт цаасыг арилжаалах замаар бүрдүүлсэн хөрөнгийн эх үүсвэрээс төсөл, хөтөлбөр сонгон санхүүжүүлэх асуудлыг тухай бүр Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэж, УИХ-ын даргад бичгээр танилцуулж байх;
  2. Засгийн газрын үнэт цаас арилжаалж бүрдүүлэх хөрөнгийн эх үүсвэрээр Монгол Улсын эдийн засгийн бие даасан, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн, үр ашиг, эргэн төлөгдөх баталгаа бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжинд санхүүжүүлэх;
  3. Засгийн газрын үнэт цаасыг арилжаалах замаар бүрдүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг төсвийн алдагдлыг нөхөх, төсвийн урсгал зардал, тэр дундаа нийгмийн халамжийн аливаа үйлчилгээнд зарцуулахгүй байх;
  4. Засгийн газрын хүлээх эрсдэлийг багасгах, хөрөнгө оруулалтын орчинг дэмжих үүднээс нэг төсөл, хөтөлбөрт хийх санхүүжилт нь тухай төслийн нийт санхүүжилтийн 1/3-ээс хэтрэхгүй байх;
  5. Үүсч болох эрсдэлийг тооцож, эрсдэлийн удирдлагын механизмыг бүрдүүлэх үүднээс эдийн засгийн чиглэлийн яамд (Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Уул уурхайн яам, Эрчим хүчний яам, Үйлдвэр хөдөө аж ахуйн яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам тээврийн яам зэрэг), Монголбанк, УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хорооны удирдлага, бие даасан шинжээчдээс бүрдсэн Бодлогын зөвлөл байгуулах;
  6. Засгийн газрын үнэт цаасыг арилжаалах замаар бүрдүүлсэн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн сонголт нь ил тод, хариуцлагатай байх, төсөл, хөтөлбөр нь цаг хугацаандаа хэрэгжиж байх зарчмыг иргэний хяналтан дор хэрэгжүүлэх, Засгийн газрын бодлогын залгамж чанарыг хадгалах.

- 1.4. "Чингис бонд"-ын үндсэн төлбөр нь хугацааны эцэст нийт дүнгээр төлөгдөх бол хүүгийн төлбөрийг хагас жил тутам төлөхөөр гэрээнд тусгажээ. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

№	Бондын нэр	Жилийн хүү хувиар	Хүүгийн төлбөрийг төлөх хуваарь		Үндсэн төлбөрийг төлөх хуваарь	
			Жил тутам	Нийт	1/5/2018	12/5/2021
1	5 жилийн хугацаатай "Чингис бонд"	4.125	20.62	103.1	500.00	
2	10 жилийн хугацаатай "Чингис бонд"	5.125	51.25	512.5		1000.00
	<b>Нийт</b>		<b>71.87</b>	<b>615.6</b>	<b>500.00</b>	<b>1000.00</b>

- 1.5. Дээрхээс харахад 2017 он хүртэл жил тутам 71.87 сая ам.доллар, хугацааны эцэс хүртэл нийт 615.6 сая ам.долларыг бондын хүүгийн төлбөрт төлөхөөр байгаа ба бондын үндсэн төлбөрт 2018 онд 500.0 сая, 2021 онд 1,000.0 сая ам.долларыг төлөхөөр байна.

**Чингис бондын хөрөнгөөр санхүүжих төсөл хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, үр ашгийг тооцоо бэлэн болоогүйгээс хэрэгжилт нь удаашралтай байна.**

- 1.6. Чингис бондын талаарх УИХ-ын тогтоол, ҮАБЗ-ийн зөвлөмжийн дагуу Засгийн газар дараах тогтоолуудаар төсөл хэрэгжүүлэх чиглэлийг тогтоож, бондын хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг Хөгжлийн банкинд даалгасан байна. Үүнд:

№	ЗГ-ын тогтоолын огноо, дугаар	Зориулалт	Хэрэгжүүлэгч байгууллага	Дүн
1	2013.03.07-ны №80	Таван толгойн цахилгаан станц	ЭХЯ	50.00
2	2013.03.07-ны №81	УБ хотын автозамын 33 уулзварыг шинэчлэх, Туул, Сэлбэ голын даланг дагуулан хурдны зам барих, гэр хорооллын дэд бүтцийг цогц байдлаар сайжруулах	ЗТЯ, НЗДТГ	200.00
3	2013.03.07-ны №82	Шинэ төмөр зам төсөл	ЗТЯ, МТЗ	200.00
4	2013.03.30-ны №118	Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хот болон орон нутагт баригдах орон сууцны хороолол болон гэр хорооллын инженерийн дэд бүтцийн барилга, байгууламж, шугам сүлжээг өргөтгөх	ЗТЯ	141.8
5	2013.03.30-ны №124	Авто замын төсөл арга хэмжээ	ЗТЯ	404.16
6	2013.03.30-ны №126	Ноолуурын салбарын технологийн шинэчлэл	ҮХААЯ	68.80
7	2013.04.13-ны №141	Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд	ҮХААЯ	27.70
		Хүлэмжийн аж ахуй байгуулахад		17.40
		Ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэл		45.00
		Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэл		13.50
8	2013.05.18-ны №180	Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих	БХБЯ	14.00
9	2013.07.09-ны №263	Орон сууцны санхүүжилт	БХБЯ	100.00
	Дүн			1,282.36

- 1.7. Гэвч дараах төсөл хөтөлбөрүүдийн ТЭЗҮ, зураг төсөв, үр ашгийн тооцоо бүрэн бэлэн болоогүй байхад зээл олгосон нь "Хөгжлийн банкны тухай хууль"-ийн 10.1.2<sup>1</sup>-т заасныг зөрчсөн байна. Тухайлбал,

Таван толгойн Цахилгаан станц, Шинэ төмөр зам төслийн ТЭЗҮ бэлэн болоогүй, Улаанбаатар хотын түгжрэлийг багасгах, гэр хорооллын инженерийн дэд бүтцийг сайжруулах Гудамж төсөл ТЭЗҮ, зураг төсөвгүй, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн нийгэм, эдийн засгийн үр ашигтай, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн иж бүрдэл, эргэлтийн хөрөнгийг тодорхой тооцоогүй байна.

- 1.8. Чингис бондын хөрөнгөөс нийт 200 сая орчим ам.долларын эх үүсвэрийг Засгийн газрын ямар нэгэн шийдвэрээр хуваарилаагүй байна.

<sup>1</sup> 10.1.2- Төсөл, хөтөлбөрийн зураг төсөл, төсөв, техник, эдийн засгийн үнэлгээ хийгдсэн байх



## 1.9. Чингис бондын хөрөнгөөр доорх зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба хэрэгжилт нь дараах байдалтай байна.

*Тавантолгойн цахилгаан станц:* Тухайн ордыг түшиглэн 450 МВт-ын хүчин чадал бүхий цахилгаан станц барих төслийн эхний ээлжинд ТЭЗҮ боловсруулах, инженер геологийн судалгаа хийх, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийх зэрэг ажлууд хийгдэхээр гэрээ байгуулагдсан.

Засгийн газрын 2013 оны 80 дугаар тогтоолоор Таван толгойн цахилгаан станцын бэлтгэл ажлыг хангахад эхний ээлжинд 50.0 сая ам.доллартэй тэнцэх хэмжээний санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсний дагуу төслийн нэгжийн зардалд 3.2 тэрбум төгрөг олгосон байна.

*Гудамж төсөл:* Улаанбаатар хотын авто замын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах, хот төлөвлөлтийг сайжруулах зорилгоор нийт 33 уулзварын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх, Туул, Сэлбэ голын дагуу хурдны зам барьж, гэр хорооллын дэд бүтцийг цогц байдлаар шийдвэрлэхээр 200.0 сая ам.долларын хөрөнгө төлөвлөснөөс 2013 онд нийт 15 уулзварыг өргөтгөх ажлыг гүйцэтгэж 2013.09.30-ний өдрийн байдлаар гүйцэтгэлээр нь нийт 30.4 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн байна.

*Шинэ төмөр зам:* Тавантолгой-Сайншанд-Чойбалсан, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн нийт 1800 км төмөр замд 2 өртөө, 5 зөрлөг, 16 гүүр, 132 малын гарц хоолой барихаар нийт 200.0 сая ам.долларын хөрөнгө төлөвлөснөөс нийт 267 км төмөр замын барилгын ажлын газар шорооны ажил, ухмал болон далангийн ажилд 138.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

*Нийслэлийн инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц төсөл:* Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын 7 орон сууцны болон 10 гэр хорооллын, орон нутагт шинээр баригдах орон сууцны болон гэр хорооллын инженерийн дэд бүтцийн барилга, байгууламж, шугам сүлжээг өргөтгөх нийт 92 төсөлд 416.8 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс нийслэлийн Буянт-Ухаа орон сууцны хорооллын 10 ш цахилгааны ЦТП, цэвэр усны 20 ш эх үүсвэрийн гүний худаг, 2 ш усан сан, насос станц, Ирээдүй цогцолбор хорооллын бохир усны 4950 м гол шугам, насосны станцын зураг төсөл, барилга угсралтын ажил, Баянголын амны орон сууцны хорооллын цахилгаан хангамжид зориулан 10 кв-ын түгээх сүлжээнд 13.0 МВт орчим чадлын хэрэглээг хангах хуваарилах байгууламж 3 иж бүрдэл, түүний кабель шугамын зураг зураг төсөл, барилга угсралтын ажил, 10 ш ус дулаан дамжуулах төвийн барилга угсралтын ажил, Яармагийн гүүр орчмын орон сууцны хорооллын цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажил, Ховд аймгийн төвийн 4200 м<sup>3</sup> хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажил зэрэгт 52.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

*Аймгийн төвүүдийг УБ хоттой холбох орон нутгийн замын төсөл:* Энэ төслийн хувьд 2013 онд шинээр хэрэгжих 10, он дамжин хэрэгжих 14 зам барилгын ажилд 570.0 хүртэл тэрбум төгрөгийн хөрөнгө төлөвлөгдөж, 6 аймгийг нийслэлтэй нийт 1800 км хатуу хучилттай замаар холбохоос 620 гаруй км замыг шинээр бүрэн хучиж, 150 км замын суурийн ажил хийгдэж нийт 257.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

*Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн 5 салбарын техник тоног төхөөрөмжийн шинэчлэл төсөл:* Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2013 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор үйлдвэрлэлийг дэмжих, технологийн шинэчлэл хийхэд зориулан ноолууран, ноосон, оёмол, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хүлэмжийн аж ахуйн салбарт үндсэн хөрөнгийн зориулалтаар 269.0 тэрбум төгрөгийн зээлийг олгохоор шийдвэрлэн Голомт банктай ерөнхий нөхцөл тохиролцох, хамтран ажиллах гэрээг 2013 оны 8 дугаар сарын 8-ны өдөр байгуулж, дэд зээлийн хүү 8 хувиас хэтрэхгүй, хугацаа 4 жил буюу 2017 оны 12 дугаар сарын 1-ны өдөр хүртэл, нийт санхүүжилтийн гуравны нэгтэй тэнцэх хэмжээгээр олгохоор тохиролцсоны дагуу 2013 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал, Голомт банкны гүйцэтгэх захиралтай төсөл санхүүжүүлэх З-ҮТТ-ХО 2013-140 тоот гэрээ байгуулж, 269.0 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт хийгдсэн. Голомт банкинд нийт 184 төсөл ирснээс 38 төсөлд 52.2 тэрбум төгрөгийн зээл олгох шийдвэр гарсан нь банкинд олгосон нийт эх үүсвэрийн 19.4 хувьтай тэнцэж байна.

*Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих төсөл:* Эрэл ХХК-ийн хэрэгжүүлэх 27.1 сая долларын өртөгтэй БҮК-1 төсөлд Засгийн газрын 2013 оны 180 дугаар тогтоолоор 14.0 сая ам.доллар олгохоор шийдвэрлэсний дагуу Хөгжлийн банкнаас 14.0 сая ам.долларын

санхүүжилтийг 2013 оны 8 сард олгосон байна. Жилд 150,000 м3 барилгын хавтан үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг 2014 онд ашиглалтад оруулахаар төлөвлөж ХБНГУ-ын Ebase компанитай тоног төхөөрөмжийн гэрээгээ байгуулсны дагуу бондын хөрөнгөөс олгосон нийт санхүүжилтийн 50 хувийг тоног төхөөрөмж захиалах гэрээний урьдчилгаанд шилжүүлж, үлдэх хөрөнгөөр үйлдвэрийн байрыг шинэчлэн засварлах ажил хийгдэж байна.

*Орон сууцны санхүүжилт:* Буянт-Ухаа орон сууцны хорооллын санхүүжилтэд 20.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгожээ.

**Чингис бондын хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хөрөнгийн 59 хувь нь төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй байна.**

- 1.10. Чингис бондын хөрөнгийг зах зээлд байршуулах, урт хугацаанд удирдах үүргийг Монголбанк хэрэгжүүлж, Засгийн газраас баталсан төлөвлөгөөний дагуу Хөгжлийн банкинд 2013 онд нийт 964.39 тэрбум төгрөгийг шилжүүлжээ.
- 1.11. Дээрх санхүүжилтээс 2013 оны 9 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Хөгжлийн банкнаас 765.0 тэрбум төгрөгийн зээлийг Засгийн газрын тогтоолоор чиглэл болгосон 204 төсөлд олгосныг хүснэгтээр үзүүлбэл:

	Төслийн зориулалт	Засгийн газраас баталсан		Хөгжлийн банкнаас олгосон	
		Төслийн тоо	дүн	Төслийн тоо	дүн
	<b>Улсын төсвөөс эргэн төлөгдөх</b>	<b>198</b>	<b>1,417.1</b>	<b>198</b>	<b>451.5</b>
1	Авто зам	104	901.4	104	257.3
2	Дэд бүтэц	92	100.0	92	52.5
3	Цахилгаан станц	1	83.1	1	3.2
4	Төмөр зам	1	332.6	1	138.5
	<b>Төслөөс эргэн төлөгдөх</b>	<b>6</b>	<b>585.0</b>		<b>313.5</b>
5	Гехник, тоног төхөөрөмжийн шинэчлэл	2	270.7	2	270.2
6	Барилгын материалын үйлдвэрлэл	1	23.3	1	23.3
7	Агаарын тээвэр	1	41.6	0	0.0
8	Уул уурхай	1	83.1	0	0.0
9	Орон сууцны барилга	1	166.3	1	20.0
	<b>Нийт</b>	<b>204</b>	<b>2,002.1</b>	<b>202</b>	<b>765.0</b>

/тэрбум төгрөг/

- 1.12. Хүснэгтээс харахад Засгийн газрын тогтоолоор нийт 204 төсөлд 2,002.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэснийг Хөгжлийн банкнаас нийт 202 төсөл хөтөлбөрт 765.0 тэрбум төгрөг буюу 38.2 хувийн санхүүжилтийг олгож, батлагдсан хуваариас 1,237.1 тэрбум төгрөгийн санхүүжилт дутуу санхүүжигджээ. Төслийн зориулалтын задаргааг төсөл бүрээр хавсралт №1-ээр үзүүлсэн бөгөөд Чингис бондын хөрөнгөөр санхүүжсэн төсөл хөтөлбөрийн 59.0 хувийг **Улсын төсвөөс**, 41 хувийг дэд төслүүдийн үйл ажиллагааны ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон байна.
- 1.13. ҮАБЗ-ийн зөвлөмжид төслийн нийт төсөвт өртгийн 1/3 хувийг Чингис бондын хөрөнгөөр, үлдэх хувийг тухайн төслийн хэрэгжүүлэгч болон бусад эх үүсвэрээр бүрдүүлэхээр тусгасан боловч энэ заалт зөвхөн техник тоног төхөөрөмжийн шинэчлэлд зориулж Голомт банкаар дамжуулан аж ахуй нэгжүүдэд олгож байгаа төслийн хүрээнд хэрэгжиж, бусад төслүүдэд хэрэгжихгүй байна.

**Төслийн нэгжийн үйл ажиллагааны зардлыг бондын хөрөнгөөс санхүүжүүлж байна.**

- 1.14. Засгийн газрын 2013 оны 46 дугаар тогтоолоор "Улаанбаатар хотын авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх, гэр хорооллын дэд бүтцийг цогц байдлаар шийдвэрлэх зорилго бүхий "Гудамж төсөл", 2013 оны 71 дүгээр тогтоолоор "Шинэ төмөр зам", Дорнод, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Баянхонгор, Хөвсгөл аймгийн төвийг УБ хоттой авто замаар холбох төсөл, Тавантолгойн нүүрсний орд газарт 300 МВТ цахилгаан станц барих төсөл, ус, дулаан хангамж, ариутгах татуургын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх "Дэд бүтэц" төсөл, үйлдвэрлэлийг дэмжих, технологийн шинэчлэл хийх зорилго бүхий "ноолууран, ноосон, оёмол, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хүлэмжийн аж ахуйн 5 төсөл" зэрэг төслүүдийг Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх, хэрэгжилтийг нь зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий төслийн нэгжийг байгуулахаар шийдвэрлэсэн байна.
- 1.15. Дээрх төслийн нэгжүүдийн болон хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн үр дүнг нэмэгдүүлэх, хяналтыг сайжруулах зорилгоор "Засгийн газрын тухай хууль"-ийн 24.2<sup>2</sup>, "Төсвийн тухай хууль"-ийн 11<sup>1</sup>.1<sup>3</sup>, "Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль"-ийн 12.1<sup>4</sup> дэх хэсгүүдийг үндэслэн "Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам"-ыг ЭЗХС-ын 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 29 дүгээр тушаалаар баталжээ.
- 1.16. Энэхүү журам нь "Төсвийн тухай хууль"-ийн 11<sup>1</sup>.1.1-д заасан "хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны нөхцлийг тогтоох, уг үнэт цаасны төлбөрийн хуваарийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн шийдвэрлэх" гэсэн заалтыг хангаагүй байна.
- 1.17. Мөн Засгийн газрын бондын хөрөнгөөр төсөл санхүүжүүлэх ерөнхий нөхцлийг тохиролцох 09/01/3-73 тоот гэрээг Хөгжлийн банкны тухай хуулийн 7, 8, 9 дүгээр зүйл, Засгийн газрын тогтоолуудыг үндэслэн ЭЗХЯ, ТХН, Хөгжлийн банкны хооронд 2013 оны 5 дугаар сарын 1-ний өдөр байгуулжээ.
- 1.18. Энэхүү гэрээний 2.1.2-т<sup>5</sup>, 2.1.3<sup>6</sup> дах заалтаар төслийн нэгжийн үйл ажиллагааны зардлыг бондын хүүг 1.0 хувиар нэмэгдүүлэн тооцож бондын хөрөнгөөр санхүүжүүлж, жил бүр дараа оны улсын төсвөөс төлөвлөж санхүүжүүлж байхаар зохицуулагдсан байгаа нь ҮАБЗ-ийн зөвлөмжийн 3-т заасантай зөрчилдөж байгааг зэрэгцээ 2014 оны улсын төсөвт төслийн нэгжийн урсгал зардал төлөвлөгдөөгүй байна.

<sup>2</sup>Монгол Улсын сайд эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэдгээрээс батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангана.

<sup>3</sup>Төсвийн тухай хуулийн 11.1.1-ийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 11<sup>1</sup>.1.1. хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны нөхцөлийг тогтоох, уг үнэт цаасны төлбөрийн хуваарийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн шийдвэрлэх; 11<sup>1</sup>.1.2. зээл, тусламжийн нэгдсэн бодлого, зохицуулалтын удирдлагыг хэрэгжүүлэх.

<sup>4</sup>Гадаадын зээл, тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

<sup>5</sup>Засгийн газрын бондын хөрөнгөөр төсөл санхүүжүүлэх ерөнхий нөхцлийг тохиролцох 09/01/3-73 тоот гэрээг 2.1.2-т "Санхүүжилтийн үндсэн хүү нь жилээр илэрхийлэгдсэн бөгөөд Засгийн газрын бондын эх үүсвэрийн зардал дээр үйл ажиллагааны зардал болох санхүүжилтийн дүнгийн 1.0 хувийг нэмсэнтэй тэнцүү байна. Санхүүжилтийн хүүг хагас жил тутамд төлнө."

<sup>6</sup>2.1.3-т "Санхүүжилтийн эргэн төлөлт нь тухайн төслийг хэрэгжүүлж эхэлсний дараа оны улсын төсөвт тусгагдаж, санхүүжилтийн эх үүсвэрийн хугацаатай уялдах зарчмыг баримтлан тогтоосон эргэн төлөлтийн хуваарийн дагуу хийгдэнэ" гэж заасан байна

1.19. 2013 оны 3 дугаар улирлын байдлаар Хөгжлийн банк бондын хөрөнгөөс төслийн нэгжүүдийн үйл ажиллагааны зардалд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр 7.5 тэрбум төгрөгийг санхүүжүүлжүүлсэн бөгөөд үүнд жилд дунджаар 429.0 сая төгрөгийн хүүгийн зардал нэмэгдэж тооцогдохоор байна.

1.20. Төслийг хэрэгжүүлэх нэгж байгуулах, үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, орон тоог батлах, хянах, түүнийг санхүүжүүлэх үйл ажиллагаа нь ЭЗХС-ын тушаалаар баталсан журмаар зохицуулагдаж байгаа ба тухайн төслүүдийн үйл ажиллагааны зардал нь төсвийн байгууллагуудтай харьцуулахад хэт өндрөөр тогтоогдож байна. Тухайлбал:

Төслийн нэгжийн мэргэжилтний сарын дундаж цалин 3.0 сая төгрөг байгаа нь төрийн байгууллагын ажилтны дундаж цалингаас даруй 6 дахин их байна.

### **Чингис бондын хөрөнгөөр шууд гэрээ байгуулан төсөл хөтөлбөрийг санхүүжүүлж байна**

1.21. Төсвийн тухай хуулийн 4.1.5 “төсөв” гэж төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, *санхүүгийн амлалт болон үүрэг*, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг” хэлнэ гэж тодорхойлсон байна.

1.22. Засгийн газрын баталгаагаар бий болгосон бондын хөрөнгө нь Тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8<sup>7</sup>, Төсвийн тухай хуулийн 6.3.3<sup>8</sup>, 6.3.4<sup>9</sup>-т заасны дагуу улсын төсвийн бүрэлдэхүүн болно.

1.23. Төсвийн тухай хуулийн 6.4.4-т “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох” гэж заажээ.

1.24. Гэтэл ГЗТЗТХ-ийн 3.1.5<sup>10</sup>-д заасан хэрэгжүүлэгч нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 3.6<sup>11</sup>-г үндэслэн харьцуулалтын арга болон шууд гэрээ байгуулж байгаа нь бондын хөрөнгийг хяналтгүй, үр ашиггүй зарцуулах нэг нөхцөл болж байна. Тухайлбал,

- “Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын 2011 оны 105 дугаар тогтоолоор зураг төслийн 41, авто замын барилгын ажлын 27 төсөл арга хэмжээний жагсаалтыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэхээр баталсан;
- Засгийн газрын 2011 оны 336, 2012 оны 106 дугаар тогтоолуудаар хүчингүй болгосон Улаанбаатар–Мандалговь 104 км авто замыг барих ажлын гэрээг Хөгжлийн банкны Зээлийн хорооны 2012 оны 6 дугаар сарын 25-ний өдрийн 018 дугаартай шийдвэрээр 49.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр барихаар шийдвэрлэсэн нь Засгийн газрын тогоолыг зөрчсөн байна.
- Замын-Үүд дэх гаалийн 11 км замын төсөвт өртөг 33.0 тэрбум төгрөгөөр хийхээр тооцсон нь зах зээлийн үнээс хэт өндөр байна.

<sup>7</sup>Төсвийн тухай хуулийн 4.1.8-д “Засгийн газрын дотоод, гадаад зээл, ...Засгийн газрын баталгаа, өрийн бичиг ...”-г “Улсын өр” гэнэ

<sup>8</sup>Төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагааг төсөвт тусгах

<sup>9</sup>Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх

<sup>10</sup>Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хуулийн 3.1.5. “төсөл хэрэгжүүлэгч ” гэж гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих төслийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэхээр Засгийн газраас эрх авсан байгууллагыг;

<sup>11</sup>ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 3.6 “Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй”

1.25. Засгийн газрын тогтоолоор бондын хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийн төсөвт өртгийг ихээхэн хэмжээгээр нэмэгдүүлжээ. Тухайлбал:

- Засгийн газрын 2011 оны 336 дугаар тогтоолоор авто замын 13, зөвлөх үйлчилгээний 31 төсөл арга хэмжээний жагсаалт батлахдаа өмнөх 105 дугаар тогтоолоор баталсан 13 замын барилгын ажлын төсөвт өртгийг 61.6 тэрбум төгрөгөөр өсгөсөн;
- Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор 2011 оны 336 дугаар тогтоолоор хүчингүй болсон 14 төсөл арга хэмжээг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэхээр тусгахдаа 14.2 тэрбум төгрөгөөр төсөвт өртгийг нэмэгдүүлэн баталсан;
- Засгийн газрын 2012 оны 110 дугаар тогтоолын 308.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгагдсаны 6 төсөл арга хэмжээний гэрээний дүнг 2013 оны 124 дүгээр тогтоолоор 79.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан;

1.26. Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй ААН-үүдэд автозамын ажлыг дахин олгосон нь ажил удааширах шалтгаан болжээ. Тухайлбал:

- Өндөрхаан–Чойбалсан чиглэлийн 143 км хатуу хучилттай 60.7 тэрбум төгрөгийн өртөгтэй авто замын төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр “Насны зам” ХХК шалгарч 2010 оны 7 дугаар сарын 15 өдрөөс 2012 оны 11 дүгээр сарын 01-ны хооронд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч өнөөг хүртэл барилгын ажил дуусаагүй байна. Тус компани нь гэрээний үүргээ биелүүлээгүй байхад дээрх чиглэлд 14.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 30 км авто замын ажлыг 2013 оны 6 дугаар сарын 14-ны өдөр гэрээгээр дахин олгосон;
- Говь-Алтай-Баянхонгор чиглэлийн 54.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 128 км замын гүйцэтгэгчээр шалгарсан “Шинжиан Шин Фа” ХХК-ын ажил дуусаагүй байхад Улаангом-Наранбулаг чиглэлийн 49.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий 90 км авто замын ажлыг давхардуулан олгосон;

1.27. Техникийн нөхцөл аваагүй төсөл арга хэмжээг сонгон шалгаруулсан нь ажил эхлэх үндэслэлгүй болсон, төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан болж байна. Тухайлбал;

- Ирээдүй цогцолбор хорооллын цэвэр усны ф150-350 мм-ийн 4377 м гол шугам, усан сангийн зураг төсөл, барилга угсралтын ажил нь 2013 онд хэрэгжих төлөвлөгөөтэй байсан боловч УСУГ-аас техникийн нөхцөл олгоходоо Ирээдүй хорооллын хэрэгжүүлэгч компанийн эзэмшил газарт шинээр 8ш худаг гаргуулах талаар шаардлага тавьсан тул асуудал шийдвэрлэгдэхгүй удааширч байна.
- Буянт–Ухаа хорооллын цахилгааныг “Шинэ яармаг станц” дэд станцаас авахаар төлөвлөсөн боловч уг станц 2013 онд ашиглалтад ороогүйгээс ус дулаан дамжуулах төв, бохир усны шугамын өргөлтын насос зэргийг цахилгаанаар хангаж чадахгүй болсон. Мөн трассын уртыг буруу тооцож төлөвлөснөөс хэмжээ болон төсөвт өртөг нь өссөнөөс (3.0 км кабель шугамын ажилд 352,0 сая төгрөг батлагдсан байтал бодит хэмжилтээр 8 км шугамын өртөг нь 871,8 сая төгрөг болсон) хэрэгжилт удаашралтай байна.

***Хөгжлийн банкны өөрийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй төслийн талаар***

1.28. УИХ-ын 2011 оны 15 дугаар тогтоолыг үндэслэн “Үнэт цаас болон Засгийн газрын баталгаа гаргах тухай” Засгийн газрын 2011 оны 85, 322 дугаар тогтоолоор Хөгжлийн банк 600.0 сая ам.долларын үнэт цаас гаргахыг тус банкинд, уг үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрт Засгийн газрын баталгаа гаргахыг Сангийн сайдад зөвшөөрсөн.

1.29. Үүний дагуу 600.0 сая ам.доллар хүртэлх хэмжээний үнэт цаасыг олон улсын зах зээлд гаргахтай холбоотойгоор Баталгааны гэрээ, Итгэмжлэлийн гэрээ, Агентын гэрээ, Хөтөлбөрийн гэрээ зэрэг үнэт цаасыг гаргахад шаардлагатай баримт бичгүүдэд Сангийн сайд 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр гарын



үсэг зурж, эхний ээлжийн **20.0** сая ам.долларын, жилийн **6** хувийн хүүтэй, 1 жилийн хугацаатай үнэт цаасыг хаалттай хэлбэрээр олон улсын зах зээлд 2011 оны 12 дугаар сарын 9-ний өдөр арилжаалсан. Үлдэх **580.0** сая ам.долларын, жилийн **5.75** хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай үнэт цаасыг нээлттэй хэлбэрээр 2012 оны 3 дугаар сарын 21-ний өдөр олон улсын зах зээлд арилжаалжээ.

1.30. Дээр дурдсан Засгийн газрын баталгаагаар олон улсын санхүүгийн зах зээлд арилжаалсан 600.0 сая ам.долларын бондын хөрөнгөөр дараах салбарт зээлийн үйл ажиллагаа явуулж байна.

<i>Төслийн нэр</i>		<i>ЗГ-ын тогтоолын дүн</i>	<i>/тэрбум төгрөгөөр/ Нийт олгосон дүн</i>
<b>Улсын төсвөөс эргэн төлөгдөх</b>		<b>1,208.74</b>	<b>511.02</b>
1	Авто зам	794.1	273.8
2	Дэд бүтэц	4.5	2.5
3	Орон сууцны зээлийн санхүүжилт	80.0	80.0
4	ЖДҮ-ийг хөгжүүлэх сан	50.0	36.5
5	Сайншанд АҮЦ	14.2	0.0
6	Цахилгаан станц	174.6	80.9
7	Төмөр зам	91.5	37.4
<b>Төслийн орлогоос эргэн төлөгдөх</b>		<b>859.69</b>	<b>598.51</b>
8	Орон сууцны барилга	151.2	7.5
9	Уул уурхай	19.4	17.1
10	Эрдэнэс таван толгой	498.8	332.6
11	Агаарын тээвэр	190.3	139.5
12	Барилгын материал үйлдвэрлэл	-	101.9
<b>Нийт</b>		<b>2,068.4</b>	<b>1,109.5</b>

1.31. Дээрх хүснэгтээс харахад нийт зээлийн 46.05 хувийг улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцлөөр, 53.95 хувийг тухайн төслөөс эргэн төлөгдөх нөхцлөөр олгосон байна.

**Чингис бонд болон Хөгжлийн банкны өөрийн гаргасан бондын хүүгийн төлбөрт жилд 105.23 сая ам.доллар төлж байна**

1.32. Олон улсын зах зээлд гаргасан бондын үндсэн төлбөр нь хугацааны эцэст нийт дүнгээр төлөгдөх бол хүүгийн төлбөрийг хагас жил тутам төлөхөөр гэрээнд тусгажээ. Хүснэгтээр үзүүлбэл:

№	Бондын нэр	Хүүний төлбөрийг төлөх хуваарь			Үндсэн төлбөрийг төлөх хуваарь			
		Хагас жил тутам	Жил тутам	Нийт	12/25/2013	3/21/2017	1/5/2018	12/5/2021
1	580.0 сая ам.долларын	16.68	33.36	166.75		580.00		
2	Дотоодын банкинд гаргасан 78.7 сая ам.долларын бонд			3.8	78.55			
3	Чингис бонд 5 жил	10.31	20.62	103.1			500.00	
4	Чингис бонд 10 жил	25.63	51.25	512.5				1,000.00
<b>Нийт</b>		<b>52.62</b>	<b>105.23</b>	<b>786.15</b>	<b>78.55</b>	<b>580.00</b>	<b>500.00</b>	<b>1,000.00</b>

1.33. Дээрхээс харахад 2017 он хүртэл бондын хүүгийн төлбөрт жил тутам 105.23 сая ам.доллар, хугацааны эцэст нийт 786.15 сая ам.долларыг төлөхөөр байгаа ба бондын үндсэн төлбөрийг 2017, 2018, 2021 онуудад төлөхөөр байгаа нь тухайн онуудад Улсын төсөв, Хөгжлийн банкны төлбөрийн чадварт дарамт учрахаар байна.



## **Дүгнэлт**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Засгийн газрын тогтоолоор бондын хөрөнгийг юунд зориулах, хэзээ хэрэглэхийг тооцоогүй, урьдчилан бэлтгэл хангагдаагүй, зураг төсөвгүй, ТЭЗҮ боловсрогдоогүй, техникийн нөхцөл, газрын асуудлыг шийдвэрлээгүй ажлуудыг баталснаас тооцоо судалгаа, хайгуул зураг төсөл боловсруулахад ихээхэн цаг хугацаа алдаж бондын хөрөнгийг бүрэн ашиглаж чадаагүй байна.
2. Чингис бондын хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын талаарх ҮАБЗ-ийн гаргасан зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.
3. Чингис бондын хөрөнгөөр богино хугацаанд ашгаа өгөх, эргэн төлөгдөх баталгаа бүхий үйлдвэрлэлийн салбарын төсөл хөтөлбөрийг санхүүжүүлээгүй нь ирээдүйд төсөвт дарамт учруулж болзошгүй байна.
4. Чингис бондын хөрөнгийг зарцуулах хуулийн зарим заалтууд (Хөгжлийн банкны тухай, Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай, ТБОНӨХБАҮХАТ хуулиудын зарим заалтууд) зөрчилдөж байгаа нь бондын хөрөнгийг хяналтгүй, ил тод бус, үр ашиггүй зарцуулах үндэс болж байна.
5. Бондын хөрөнгөөр санхүүжиж байгаа төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны санхүүжилт өндөр, төслийн нэгжийн зардлыг эргэн төлөгдөх эх үүсвэрийг төсөвт тусгаагүй байна.

## **Зөвлөмж**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт зөвлөж байна. Үүнд:


1. Засгийн газрын бондын хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгон Хөгжлийн банкны тухай хуулийн холбогдох заалтуудыг бусад хууль эрх зүйн актуудтай нийцүүлэх ажлыг судалж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх,
2. Зураг төсөв, ТЭЗҮ нь бэлэн болсон эдийн засгийн өгөөжөө богино хугацаанд өгөх, нэн тэргүүний шаардлагатай төсөл, хөтөлбөрүүдийг сонгон шалгаруулах,
3. Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, орон тоо, төсөв, санхүүжилтийг хянах тогтолцоог бий болгох,
4. Чингис бондын хөрөнгөөр санхүүжүүлж буй төсөл хөтөлбөрийн мэдээллийн баазыг бий болгож ил тод болгож, хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах,

## Бүлэг 2 Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын ашиглалт, үр нөлөөг тооцох ажил хангалтгүй байна.

### Ерөнхий мэдээлэл


#### Хөнгөлөлттэй зээлийн талаар

2.1. Монгол Улс хөрөнгө оруулалтыг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх, улс орны эдийн засгийн хөгжилд түлхэц болохуйц төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагуудаас 2008-2013 оны 9 дүгээр сарын байдлаар нийт 904.7 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийг авч ашиглажээ. Графикаар харуулбал:



\*Эх сурвалж Сангийн яам

2.2. 2008-2013 оны хооронд хөнгөлөлттэй зээлээр нийт 50 төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлсний 25 төсөл нь хэрэгжиж дууссан, 25 төсөл нь хэрэгжиж байгаа бөгөөд нийт зээлийн 77.1 хувийг эдийн засгийн салбарт, 19.8 хувийг нийгмийн салбарт зарцуулсныг графикаар харуулбал:




#### Буцалтгүй тусламжийн талаар

2.3. Монгол Улсын Засгийн газар 1991 оноос 2011 оны хооронд хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагуудаас эдийн засгийн өсөлтийг дэмжих, эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчин, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, ядуурлыг бууруулж, хөдөлмөр эрхлэлтийг

дэмжих, хөдөө аж ахуйн, үндэсний үйлдвэрлэл болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох, боловсролын салбарт сургууль цэцэрлэгийн барилга барих, шинэчилсэн стандартыг бий болгох зэрэг чиглэлээр нийт 2,7 тэрбум ам.долларын буцалтгүй тусламж авч ашиглажээ.

2.4. 2008-2013 оны байдлаар авсан буцалтгүй тусламжаар нийт 727.49 сая ам.долларын тусламж авсныг графикаар харуулбал:



2.5. 2008-2013 оны 9 дүгээр сарын байдлаар буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 144 төсөл хэрэгжүүлснээс 73 нь хэрэгжиж дууссан, 57 нь хэрэгжиж байна. Тусламжийн ашиглалтыг хэрэгжиж буй салбар, чиглэлээр үзүүлбэл:

Хамарсан хүрээ	2008-2013 онд хэрэгжиж дууссан		2008-2013 хэрэгжиж байгаа		Нийт дүн	Нийт тусламжид эзлэх хувийн жин
	Төслийн тоо	Гүйцэтгэл (мянган. ам.доллар)	Төслийн тоо	Мөнгөн дүн (мянган. ам.доллар)		
Боловсрол	3	12,613.23	5	51,291.84	63,905.07	11.47
Хөдөө аж ахуй	11	32,503.53	8	13,882.91	46,386.44	8.32
Эрх зүйн чиглэл	2	4,649.57	1	1,411.15	6,060.72	1.09
Нийгмийн хамгаалал, хүнс тэжээл	1	7,600.00	2	3,131.05	10,731.05	1.93
Уул уурхай				2	4,747.31	0.85
Эрчим хүч	6	31,625.41	4	5,789.94	37,415.35	6.71
Зам, тээвэр	2	47,744.77	4	23,595.73	71,340.50	12.80
Эрүүл мэнд	8	2,981.22	14	57,687.08	60,668.31	10.89
Байгаль орчин	12	44,617.83	9	14413.2462	59,031.08	10.59
Харилцаа, Холбоо	2	14,652.49			14,652.49	2.63
Барилга, хот байгуулалт	6	6,952.90	3	12,460.00	19,412.90	3.48
УБ хотын хөгжил	4	14,000.00	4	11,223.29	25,223.29	4.53
Санхүүгийн салбар	7	43,318.23	5	31,372.03	74,690.26	13.40
Соёлын салбар	6	3,047.82	1	4,967.50	8,015.32	1.44
Хөдөлмөр эрхлэлтийн талаар	4	11,350.43	3	37,854.39	49,204.82	8.83
Бусад	3	5,320.00	20	532.63	5,852.63	1.05
	77	282,977.44	67	274,360.09	557,337.52	100.00

\*Эх сурвалж: Сангийн яам

2.6. Хүснэгтээс үзэхэд боловсрол, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам тээвэр, эрүүл мэнд, байгаль орчны болон санхүүгийн салбарт буцалтгүй тусламжийн дийлэнх хувийг хэрэгжүүлсэн байна.

**Гадаадын зээл, тусламжийг зохицуулах нэгдсэн бодлого дутагдаж байна**

2.7. 2008-2012 онд Засгийн газрын тухай хуулийн 20.5.4<sup>12</sup>, ГЗТЗТХ-ийн 5.1<sup>13</sup>, 5.3<sup>14</sup>-т заасны дагуу гадаадын зээл, тусламжийн нэгдсэн бодлогын төлөвлөлт,

<sup>12</sup>ЗГ-ын тухай хуулийн 20.5.4 "МУ-ын Сангийн сайд нь зээл, тусламжийн нэгдсэн бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ

боловсруулалт, удирдлага, зохион байгуулалтын болон дүн шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлыг Сангийн яам хариуцаж байсан бол шинэчлэлийн Засгийн газрын бүтцээр ЭЗХЯ нь улсын төсөв, зээл, тусламж, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө болон Хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүдийг төлөвлөх, зохион байгуулах, бодлогын удирдамжаар хангах, Сангийн яам нь хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжилтийн эрх нээх, хэрэгжилтэд хяналт тавин, төлбөр тооцоо, санхүүжилт, мэдээллийн санг хариуцаж байна.

2.8. ГЗТЗТХ-иар Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн стратеги, хэтийн чиглэл, улсын төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь гадаадын зээл, тусламжийн бодлоготой уялдсан байх ёстой ч энэ талаар тодорхойлсон бодлогын баримт бичгүүд байхгүй байна.

2.9. Хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хэрэгцээ, шаардлагыг гадаадын зээл, тусламжийн талаарх бодлого, хөгжлийн стратегид нийцүүлэн тухайн салбар, орон нутгийн хэмжээнд боловсруулах, төслийн ТЭЗҮ-ийг салбарын яам хариуцан боловсруулж, гадаадын зээл, тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэхээр заасан байна.

2.10. Гэтэл бодит байдалд Засгийн газрын тогтоолуудаар баталсан үндэсний хөтөлбөрүүдийн зорилтод үндэслэсэн төсөл хэрэгжүүлэгч байгууллагын санал болгосон хүсэлт, боловсруулсан төслийн хүрээнд хөгжлийн хоёр талт хамтын ажиллагаатай<sup>15</sup> байгууллагууд санхүүгийн дэмжлэг өгөх, төсөл хэрэгжүүлэхдээ голчлон тухайн улсын Засгийн газар, ОУБ-ын шийдвэрийг хэрэгжүүлдэг, төсөл хэрэгжүүлэх салбар чиглэл, хамрах хүрээ, стратегиа Сангийн яамтай ерөнхийд нь тохиролцож, Засгийн газартай байгуулсан хэлэлцээр болон тохиролцсон ерөнхий стратегийн хүрээнд тусламжийн гэрээг мэргэжлийн байгууллагуудтай байгуулан хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнд яамдын оролцоо харьцангуй бага байна. Тухайлбал:

- Соёлын салбарт хэрэгжсэн 6 төслийг АНУ болон Японы ЭСЯ, Юнеско ОУБ, Швейцарийн хөгжлийн агентлаг, Нидерланд улсын Ханхүү Клаусын Сангаас соёлын талаар буцалтгүй тусламж үзүүлэхээр зарласан төслийн уралдаанд мэргэжлийн байгууллагууд (Соёлын өвийн төв, Дүрслэх урлагийн музей, Үндэсний түүхийн музей, Чойжин ламын музей) хандсанаар хэрэгжсэн байна.
- Эрүүл мэндийн салбарт хэрэгжсэн буцалтгүй тусламжууд нь Засгийн газрын тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөрүүдийн зорилтуудыг хангахад ММСС, НҮБХАС, НҮБХС, ДЭМБ-ийн стратегийн хүрээнд чиглэгдэж, ЭМЯ-тай 2-5 жилийн ажлын төлөвлөгөө баталж, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн гүйцэтгэгчийг санхүүжүүлэгч олон улсын байгууллага өөрсдөө тендер шалгаруулан нийлүүлэгдэж байна.

2.11. Харин яамдад байгуулагдсан Зээл тусламжийг зохицуулах зөвлөл салбар дахь гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийг нэгдсэн бодлогоор хангах, олон талт хамтын ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, төрийн захиргааны төв байгууллагыг бодлогын зөвлөмжөөр хангах үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллах

<sup>13</sup> 5.1. Гадаадын зээлийн талаархи бодлого, дунд хугацааны хөгжлийн стратеги, хэтийн чиглэлд нийцүүлэн тухайн салбар, орон нутгийн хэмжээнд гадаадын зээлээр хэрэгжүүлэх төслийг боловсруулах, төслийн техник, эдийн засгийн үзүүлэлтийг тухайн салбарын яам хариуцан боловсруулж, гадаадын зээл, тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

<sup>14</sup> 5.3. Гадаадын зээл, тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрийн захиргааны бусад төв байгууллагаас ирүүлсэн төслийг хянаж, дунд хугацааны хөгжлийн стратеги, хэтийн чиглэл, улсын төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, ач холбогдол, нийгэм эдийн засгийн үр ашиг, хамтран ажиллагч талын бодлого, журамтай уялдуулан Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

<sup>15</sup> Тухайн улсыг төлөөлсөн хамтын ажиллагааны суурин төлөөлөгчийн газрууд болон техник туслалцааны байгууллагууд

ёстой ч дийлэнх яамдад энэ талаар ажил хийгдээгүй, зөвлөлийн хуралдаан хэдэн удаа болсон, хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрийн талаарх мэдээлэл, хурлын тэмдэглэл зарим яамдад байхгүй, зээл тусламжийн талаар ямар зохицуулалт хийж ажилласан нь тодорхойгүй байна.

2.12. Энэ мэтчилэн хандивлагч улс, ОУБ-ууд хооронд хийх зохицуулалтаас гадна салбарын болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын дунд уян хатан зохицуулалт хангалтгүйгээс зээл, тусламжаар хэрэгжиж буй зарим төслийн зорилт, хамрах хүрээ, үйл ажиллагааны үр дүн давхардах хандлагатай байна.

2.13. УАГ-аас 2010, 2011 онуудад хийгдсэн аудитаар<sup>16</sup> зарим төслүүдийн зорилго, чиглэл давхардаж байгаа талаар дурдаж байжээ. Үүнд:

- НХХЯ-нд хэрэгжсэн “Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хөгжүүлэх төсөл”-ийн зорилт 1-д “Ядуурлыг тодорхойлох, хэмжих аргачлалыг сайжруулж, нарийвчилсан мэдээлэл боловсруулах” гэсэн бүлэг зорилтын зарим үйл ажиллагаа “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн төсөл”-ийн зорилттой
- Нийслэлд хэрэгжсэн “Олон нийтийн оролцоонд тулгуурлан гэр хорооллын бичил дэд бүтцийг хөгжүүлэх” төслийн зорилт ЗТБХБЯ-нд хэрэгжиж буй “Гэр хорооллыг олон нийтийн оролцоотой хөгжүүлэх” төслийн зорилттой зарим талаар
- 2004 онд Төрийн албаны зөвлөлд АХБ-ны 400.0 мянган ам.долларын зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн “Төрийн захиргааны шинэтгэл” төслөөр ТАХ-ын мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулсан ч Дэлхийн банкны “Эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх техник тусламжаар дахин тусгаж 2009 он, 2010 оны эхний хагасжилд 429.9 мянган ам.долларыг зарцуулсан
- Түүнчлэн ДБ-ны “Засаглалыг дэмжих” буцалтгүй тусламжийн хүрээнд “Уул уурхайн салбарын бүртгэл ба кадастрын системийг сайжруулах” 1.9 саяам.долларын өртөг бүхий төслийг 2008 оны 11 дүгээр сараас хэрэгжүүлж эхэлсэн боловч ДБ-ны “Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техник тусламжаар төсөл”, АХБ-ны “Кадастрын зураглал газрын бүртгэл” төслүүд дээрх зорилтын дагуу давхар хэрэгжсэн байна.

2.14. Үүнээс гадна хүмүүнлэгийн ОУБ-ын шугамаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөртэй Засгийн газрын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн зорилго, хамрах хүрээ давхардаж байна. Энэ нь зээл тусламжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон салбар яамд өөрсдийн үйл ажиллагааг уялдуулахгүй байгаатай холбоотой байна. Тухайлбал:

МУЗН, Адра ОУБ, Дэлхийн зөн ОУБ зэрэг хүмүүнлэгийн байгууллагуудаас ХДХВ-аас сэргийлэх, нийгмийн эмзэг бүлэгт халамж үйлчилгээг хүргэх, байгаль орчин, эрүүл ахуй, ядуурлыг бууруулах зэрэг бүхий л чиглэлээр хүмүүнлэгийн төрөл бүрийн тусламж хэрэгжиж байхад эрүүл мэнд, байгаль орчин, хөдөө аж ахуй, нийгмийн хамгааллын салбарт мөн энэ чиглэлээр төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа ч тэдгээрийн хамтын ажиллагаа хангалтгүй, үйл ажиллагааны үр дүн давхардалд дүн шинжилгээ хийсэн зүйл салбарын яамд болон зээл тусламжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагуудад байхгүй байна.

**Судалгаанд хамрагдсан зээл тусламжийн хөрөнгийн дийлэнх хувь нь хөрөнгө оруулалтын чанартай байна**

2.15. 2008-2013 онд хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл хөтөлбөрөөс аудитад хамрагдсан төслүүдийн зарцуулалтын судалгааг гаргаж үзэхэд дараах байдалтай байна. Үүнийг яамдаар харуулбал:

<sup>16</sup> 2010 онд “Улсын өрийн удирдлагын үр нөлөө, дамжуулан зээлдүүдсэн болон эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн өрийн барагдуулалтад” (УАГ-ГАГ/2010/08-ГА), 2011 онд “Хандивлагч улс, олон улсын байгууллагаас Монгол Улсын Засгийн газрын шугамаар үзүүлж буй буцалтгүй тусламжийн ашиглалт, үр нөлөөт байдал”-д (УАГ-ГАГ/2011/06-ГА) хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангуудаас

№	Яамд	Төслийн тоо	валют нэгж	Төслийн нийт төсөв	Төслийн гүйцэтгэл	Урсгал зардал		Хөрөнгө оруулалтын зардал			Бусад	Нийт гүйцэтгэлд хөрөнгө оруулалтын эзлэх хувь	Тайлбар
						Үйл ажиллагааны зардал	Гадаад дотоод зөвлөхийн зардал	Барилга байгууламж	Их зарвар	Тоног төхөөрөмж			
<i>Хөнгөлөлттэй зээл</i>													
1	ЭХЯ	1	USD	12.00	10.88	0.14	0.50	3.07	-	7.17	-	94.14	
		2	EUR	19.00	6.41	-	1.44	0.18	-	4.78	-	77.52	
2	ЭМЯ	1	EUR	4.62	4.59					2.64		57.52	Төсөл нь хэрэгжиж дууссан тул тоног төхөөрөмжөөс өөр зарцуулалт нь тодорхойгүй
	Зээлийн дүн	1	USD	12.00	10.88	0.14	0.50	3.07	-	7.17	-	94.14	
		3	EUR	23.62	11.00	-	1.44	0.18	-	7.42	-	69.17	
<i>Буцалтгүй тусламж</i>													
1	БСШУ	5	USD	69.29	48.97	1.13	3.06	3.27	11.07	14.23	16.21	58.34	
2	ХАХНХЯ	1	USD	3.00	2.14	0.77	1.29			0.07		3.48	
3	УУЯ	2	USD	7.50	7.11	2.85	1.78			1.10	1.39	15.49	
4	ҮХААЯ	2	USD	52.70	19.06		17.78	0.19		0.37	0.72	2.93	
5	ХЗЯ	1	USD	5.00	4.23	0.10	0.72	2.76	0.20	0.26	0.19	76.24	
6	ЭЗХЯ	1	USD	1.00	1.00	1.00	-	-	-			-	
		2	EUR	19.00	12.48	-	-	-	-	0.09	-	0.7	ГТХАН-ийн төслийн нэгж ЭЗХЯ-нд үйл ажиллагаагаа хагас, бүтэн жилээр тайлагнадаг тул аудитын үйл ажиллагаанд нэмэлт мэдээлэл гаргаж өгөх болон зардлын зарцуулалтын талаар судалгаа гаргахаас татгалзсан бөгөөд төслөөс хүлээлгэн өгсөн автомашиныг тусгав.
7	БОНХЯ	4	USD	10.2	3.20	0.6	1.8			0.3	0.5	9.38	
		3	EUR	4.0	2.00	1.4	0.2			0.2	0.2	10.00	
8	ЭМЯ	12	USD	100.9	77.15	8.7	6.6	4.5	1.3	25.7	30.3	40.87	
9	ЭХЯ	6	USD	7.50	7.34	0.00	2.84	1.80	0.00	2.70	0.00	61.28	
			EUR	9.25	7.46	1.69	0.73	2.22	0.00	0.86	1.95	41.31	
10	ССАЖЯ	4	USD	0.09	0.09	0.03	0.01	-	0.01	0.03	0.01	41.08	
		1	EUR	0.02	0.01	-	-	-	-	0.01	-	100.00	
		1	JPY	47.4	45.50	3.00	-	-	-	42.50	-	93.41	
	Тусламжийн дүн	37	USD	256.2	169.3	14.2	35.9	12.5	12.6	44.8	49.3	41.29	
		6	EUR	32.3	9.55	3.1	0.9	2.2	0.0	1.2	2.2	35.34	
		1	JPY	47.4	45.50	3.0	0.0	0.0	0.0	42.5	0.0	93.41	
	Нийт зээл тусламжийн дүн	38	USD	268.2	180.17	14.3	36.4	15.6	12.6	52.0	49.3	44.48	
		9	EUR	55.9	18.60	3.1	2.4	2.4	0.0	8.6	2.2	59.04	
		1	JPY	47.4	45.50	3.0	0.0	0.0	0.0	42.5	0.0	93.41	
	Дундаж хувь											65.64	

2.16. Хүснэгтээс харахад аудитад хамрагдсан төслүүдийн зарцуулалтыг дунджаар тооцож үзвэл 65.6 хувь нь бодит хөрөнгө оруулалтын шинж чанартай арга хэмжээнд зарцуулагджээ.

2.17. Зээл, тусламжийн хөрөнгөөр хийгдэж ашиглалтад орсон хөрөнгө оруулалтыг биет хэмжээгээр харуулбал:



Барилга байгууламжийн төрөл	Хэмжих нэгж	Гүйцэтгэл	Хамарсан орон нутаг
Хатуу хучилттай автозам	Км	313.45	Хархорин-Хөшөө цайдам 46, Хэнтий-Мөрөн-Өндөрхаан 28.1, Багануур-Хэрлэнгийн гүүрийн 3, Багануур 8.5, Булган-Уньт 60, Сайншанд-Замын-Үүд 131, Замын-Үүдээс Эрдэнэ сум хүртлэх 15.5
Хайрган хучилттай автозам	Км	49.49	Хархорин-Цэцэрлэг 5.3, Дархан-Шарын гол 7.2, Зүүнхараа-Түнхэл 2.3, Дархан сум-Хушаат сум 7.3, Дархан-Жаргалант сум 7.32, Улиастай-Яруугийн гүүр хүртэл 17.05, Сэлэнгэ Жавхлантаас-Ерөө сум 3.019
Төмөр бетон гүүр	у/м	386.45	Багануур-Хужирт голын 17.55, Багануур-Хуцаа нарийний 17.55, Булган-Уньтын-Чачиртын голын 30, Хэнтий-Хэрлэн голын 268.8, Хэнтий-Мөрөнгийн голын 52.55
Эрчим хүчний шугамд холбогдсон ЦДАШугам	110/35/10 кВ	11 дэд станц	УБ, Хөвсгөл, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Сүхбаатар, Өмнөговь, Баян-Өлгий, Ховд Увс
	20 кВ swer шугам км	197.7	Төв, Булган, Дундговь Хэнтий, Дорноговь, Увс аймгийн 13 с
Сайжруулсан дулаан хангамж	0.5-0.8 МВт усан халаалт	13 сумдын халаалтын зуух	Төв, Хөвсгөл, Дорноговь, Булган, Сүхбаатар, Сэлэнгэ, Дундговь
Шинэчилсэн диспетчерийн удирдлагын хяналтын систем		13 дэд станц	УБ, Дорнод, Багануур, Эрдэнэт, Дархан, Шарын гол, Зүүнхараа, Борнуур,
Ашиглалтад орсон ЦДС	220/110/35 кВ	15 дэд станц	УБ, Дорнод, Багануур, Чойр, Хар-айраг, Бор-Өндөр, Борнуур, Шарын гол, Булган, Хархорин, Эрдэнэт, Дархан
Ашиглалтад орсон усан цахилгаан станц		1 станц	Говь-Алтай аймгийн Тайшир сум
Ашиглалтад орсон сэргээгдэх эрчим хүч	Нарны цахилгаан үүсгүүр, цахилгаан нарны станц	129 ширхэг үүсгүүр, 2 нарны цахилгаан станц	Архангай, Хэнтий, Төв, Дорноговь, Сүхбаатар аймгуудын сум баг, Говь-Алтай аймгийн Алтай сумд 202 кВт, Цогт суманд 102.6 кВт нарны станц
Гэр хорооллын агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг бууруулах арга хэмжээ	хамрагдсан өрхийн тоо	4235 өрх	УБ хотын Баянгол дүүргийн 9,10,11, 21, 23, Чингэлтэй дүүргийн 16, 17,18,19, Баянзүрх дүүргийн 27,21, Сүхбаатар дүүргийн 13,14-р хороо
Ашиглалтад орсон эмнэлэг/ орны тоо	10 ортой	10 сум	Архангай, Сүхбаатар, Говь-Алтай, Дундговь, Төв аймгуудын сумдад

**Зээл, тусламжийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй байна.**

2.18. Зээл, тусламжийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг салбарын яамд, төсөл хэрэгжүүлэх нэгж тодорхойлон гаргаж байгаа ч бодит нөхцөл байдлын судалгаа хангалтгүй, хэт хавтгайруулснаас өнөөгийн нөхцөлд тохирохгүй байх, зээл тусламжийн гэрээнд Засгийн газраас гаргах хөрөнгө оруулалт болон бэлтгэл нөхцлийг хангаагүй зэргээс аудитад хамрагдсан зарим эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй байна. Тухайлбал:

1. ЭМСХ-3 төслөөр “Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах” зорилтын хүрээнд өрх, сумдын ЭМТ-ийн статус, тусламж үйлчилгээний цар хүрээг тодорхойлж, 5 аймаг, 2 дүүргийн 90 орчим өрхийн болон ЭМТ-ийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан ч өрх, сумдын ЭМТ-ийн байрны өнөөгийн нөхцөл байдал нь тохиромжгүй, дэд бүтэц, хүн хүчний чадамж хангалтгүй, анх нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж нь дутуу нийлүүлэгдсэн, тохиргоо нь хийгдээгүй зэргээс 144.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжүүд ашиглалтгүй байна. Үүнд:

- ӨЭМТ-д олгогдсон эмийн шүүгээ нь хэт томдсоноос чийрэгжүүлэх танхимд хувцасны

шүүгээ болсон, коридорт болон агуулахад зориулалтын дагуу ашиглалтгүй байгаа 12.2 сая төгрөгийн,

- физик эмчилгээний тоног төхөөрөмжүүд нь мэргэжлийн эмчгүй, ӨЭМТ нь төвлөрсөн халаалтад холбогдоогүйгээс цахилгааны зардал нь өндөр гардгаас шалтгаалан 2 жил ашиглалтгүй байгаа 7 ӨЭМТ, 10 сумдын ЭМТ-үүдийн 121.43 сая төгрөгийн,
- Анх нийлүүлэхдээ тоног төхөөрөмжийн иж бүрдлийг дутуу нийлүүлсэн болон ашиглалтын хугацаа дуусаагүй байхад эвдрэл гэмтэл гарснаас 10.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж ашиглалтгүй байна.

2. ММСС-гаар Улсын III төв эмнэлэгт хэрэгжүүлсэн “Харвалт ба зүрхний шигдээс” төслийн хүрээнд нийлүүлэх тоног төхөөрөмжийг суурилуулахад шаардлагатай өрөө тасалгааг бэлтгэх, урсгал засваруудыг ЭМЯ болон эмнэлэг хүлээсэн ч эмнэлгийн хийн системийн төсөв хөрөнгийн асуудлыг шийдээгүй удсан, тендер зарлахад хугацаа алдсан зэргээс 2013 оны 4 сард нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүд нь одоог хүртэл бүрэн хүчин чадлаараа ашиглагдахгүй байна.

2.19. Хэдийгээр зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрөөс нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулж байгаа ч түүнд тухайн техник хэрэгсэлтэй харьцах мэргэжилтэн биш удирдах ажилтнууд нь хамрагдсан, эсвэл хамрагдсан ч бүрэн ойлголт аваагүй зэргээс ашиглалт нь хангалтгүй байна.

2.20. Мөн төслийн үр шимийг хүртэгч орон нутгийн байгууллагын удирдлага төслийн ажилд хувь нэмэр оруулах, дэмжлэг үзүүлэхээсээ илүү төслөөс эд хөрөнгө авч зарцуулах сонирхолтой бөгөөд төслийн үйл ажиллагаа дуусахад түүнийг үргэлжлүүлэн ашиглах асуудалд төдийлөн анхаарахгүй байгаагаас хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна. Тухайлбал:

Байгаль орчин, хөдөө аж ахуйн чиглэлээр иргэдийн оролцоог хангах, чадавхийг бэхжүүлэх тусламжийн төслүүдээр хийгдсэн хөрөнгө оруулалтаар хийгдсэн уст цэгүүд, хогийн цэг, нийтийн аж ахуйн үйлчилгээний төвүүд төслийн дараагаар ашиглалт хангалтгүй байна.

***Зээл, тусламжаар хэрэгжиж буй төслийн бүртгэл зөрүүтэй, түүний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.***

2.21. ГЗТЗТХ-д гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг хүлээн авах, ашиглах, тайлагнах үе шатанд тавих ерөнхий хяналтыг Сангийн яамд, өдөр тутмын хяналтыг холбогдох салбарын яамд тавихаар заажээ.

2.22. Мөн Сангийн сайдын 2006 оны 447<sup>17</sup>, 2007 оны 120, 2011 оны 86<sup>18</sup> дугаар тушаалаар батлагдсан журмуудаар Сангийн яам нь зээл, тусламжийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, нэгдсэн бодлогоор хангах ажлыг уялдуулан зохицуулах, төслийн хэрэгжилт, хяналт, үр дүнг нэмэгдүүлэх ТХН-ийн орон тоо, үйл ажиллагааны зардлыг баталж, ТХБ-ын саналыг үндэслэн зээл тусламжийн хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах, төслийн гадаад дотоод эх үүсвэрээс бүрдэх хөрөнгийн хэмжээг дараа оны төсөвт тусгах, төслийн хэрэгжилтийн зарцуулалтад зээлдэгчтэй хамтран хяналт тавих үүрэгтэй байна.

2.23. Хэдийгээр өр, зээлийн нэгдсэн мэдээллийн сан бий болсон хэдий ч Сангийн яамны гадаадын зээл, тусламжийн асуудал эрхэлж буй СБӨУГ-ын Өрийн удирлагын хэлтсийн (хуучнаар ЗТБХАГ болон ТСГ-ын Өрийн удирдлагын хэлтсийн) тусламжийн бүртгэл, мэдээ, судалгааны үнэн зөв байдалд тавьж буй хяналт хангалтгүйгээс холбогдох мэдээ тайлангууд зөрүүтэй тайлагнагдсан байна.

<sup>17</sup>Гадаадын зээл, тусламжийн бүртгэл, мэдээллийн сан байгуулах, ашиглах журам

<sup>18</sup>Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам

2.24. Сангийн яамнаас ирүүлсэн зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн нэгдсэн судалгааг яамдаас ирүүлсэн судалгаа, 2008-2013 онд Сангийн сайдын 18 тушаалаар баталсан зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн мэдээлэлтэй харьцуулж үзэхэд зөрүүтэй байна. Тухайлбал:

- Сангийн яамны судалгаагаар соёлын салбарт нийт буцалтгүй тусламжаар 8 төсөл хэрэгжиж дууссан гэсэн бүртгэлтэй ч АНУ-ын “Үзмэрийн танхимын гэрэлтүүлэг сайжруулах” 3.7 сая ам.долларын төсөл болон “Монгол Солонгосын хамтарсан төсөл” гэсэн төсөл хаана хэрэгжиж байгаа нь тодорхойгүй, Үндэсний түүхийн музейд “Солонгосын соёлын давалгаа” гэсэн нэртэйгээр 2010 онд төсөл хэрэгжсэн ч хаана ч бүртгэлгүй, ССАЖЯ-нд хэрэгжсэн болон хэрэгжиж буй төслийн нэгтгэсэн мэдээлэл байхгүй,
- ШХА-ын буцалтгүй тусламжаар Чойжин ламын музейд судар сэргээн засварлахад 16.5 сая төгрөгийн төсөл хэрэгжсэнийг 16.5 сая ам.доллар гэж Сангийн яам бүртгэсэн,
- Уул уурхайн салбарын институцыг бэхжүүлэх төсөл зээлийн болон тусламжийн хэсэгтэй бөгөөд төслийн гүйцэтгэлийн тайланд зээл тусламжийн дүнг хамтад зээлээс санхүүжүүлэх гэж нэгтгэн бүртгэсэн.
- “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл нь 11.5 сая ам.долларын зээл, 1.5 сая ам долларын тусламжийн хэсэгтэй байхад тусламжийг нь орхигдуулж, 7.5 сая ЗТЭ-ээр бүртгэсэн
- БНФУ-ын хөнгөлөлттэй зээлээр “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл”-д 9.5 сая еврогийн төслийг 26.9 тэрбум төгрөгөөр бүртгэсний зэрэгцээ орон нутагт дамжуулан зээлдүүлснийг орон нутагт 9.5 сая еврогийн зээл хэрэгжиж байгаагаар давхар бүртгэсэн.
- БХБ-ын бүртгэлээр буцалтгүй тусламжаар “Улаанбаатар хотын яармаг орчмын ус хангамжийн шинэ эх үүсвэр”, хөнгөлөлттэй зээлээр “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах” төслүүд хэрэгжиж байхад Сангийн яамны бүртгэлд байхгүй, харин зээлийн хөрөнгөөр санхүүжих “Төв Азийн усны нөөцийн нэгдсэн менежмент-Загвар бүс нутаг Монгол /Момо төсөл/-ийн Суурин газрын усны нэгдсэн менежмент /ТМ-3/ дэд төсөл”, буцалтгүй тусламжаар “Улаанбаатар хотын ундны усны хангамжийн эх үүсвэр болох худагнуудын техникийн эвдрэл гэмтлийг тодорхойлох, тэдгээрийг хэрхэн нөхөн сэргээх талаар туршилт судалгаа явуулах” төслүүд Сангийн яамны судалгаанд байгаа ч салбарын яаманд ямар нэгэн мэдээлэлгүй хаана хэрэгжсэн нь тодорхойгүй
- Зээл тусламжаар хөрөнгөөр хэрэгжсэн төслүүдийн НӨАТ-аас чөлөөлөгдөх төсөл хөтөлбөрийг Сангийн сайдын тушаалаар баталдаг бөгөөд 2008-2013 онд нийт 18 тушаал гарсныг Сангийн яамны зээл тусламжийн бүртгэлтэй тулган үзэхэд техник туслалцааны, хүмүүнлэгийн тусламжуудыг огт бүртгээгүй байна.

2.25. Үүнээс гадна зарим төсөл хөтөлбөрийн нарийвчилсан мэдээлэл, тухайлбал ямар үйл ажиллагаа, хэдий хэмжээний тусламжийг ямар салбар, чиглэл, зорилго зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн эсэх талаар нарийвчилсан мэдээлэл Сангийн яамны ӨУХ болон салбарын яамдад байхгүй байна.

2.26. Мөн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд манай улсад нийлүүлж буй бараа, техник, тоног төхөөрөмжийг Сангийн сайдын тушаалаар<sup>19</sup> гаалийн албан татвараас чөлөөлж, дотоодын зах зээлээс бэлтгэгдсэн, худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд НӨАТ-ын болон бусад албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлдэг бөгөөд тэдгээрийн мэдээг нэгтгэдэг СЯ, ГЕГ, ТЕГ хоорондоо тооцоо нийлж баталгаажуулдаггүй байна.

2.27. Энэ нь зарим төсөл хэрэгжүүлэгч байгууллага, яамдыг эс тооцвол мэдээллийн санд хүргүүлэх өгөгдөл, ашиглалтын мэдээг иж бүрэн бэлтгэж хүргүүлдэггүй, Сангийн яамны ӨУХ-т мэдээллийг ирүүлбэл зохих байгууллагын судалгаагүй, мэдээлэл ирүүлсэн ч нэгдсэн удирдлагаар хангаж ажилдаггүйтэй холбоотой байна. Үүнээс үүдэн ГЗТЗТХ болон бусад холбогдох журмын зарим заалт бүрэн хэрэгждэггүй байна. Тухайлбал,

<sup>19</sup>Үндэслэл: Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2002 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 113 дугаар тушаалаар батлагдсан “Буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламж, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр дотоодын зах зээлээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх журам”-ын 2.1 дэх заалт

Хууль, журмын нэр	Бүрэн хэрэгждэггүй заалтын		Хамрах хүрээ (Сангийн яам болон бусад яамд, мэргэжилтний түвшинд)
	тоо	дугаар	
Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хууль	3	5.3, 9.2, 12.1.3	Сангийн яам, бусад яамд
	3	12.1.6, 22.1, 23.2	Сангийн яамны төслийн санхүүжилт, зохицуулалтын газрын(хуучнаар) түвшинд
Гадаадын зээл тусламжийн бүртгэл, мэдээллийн сан байгуулах, ашиглах журам	1	1.2	Сангийн яамны төслийн санхүүжилт, зохицуулалтын газрын(хуучнаар) түвшинд
Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам	2	5.2.4, 16.1	Сангийн яамны төслийн санхүүжилт, зохицуулалтын газрын(хуучнаар) түвшинд
Гадаад зээлийн үндсэн болон хүүгийн төлөх журам	6	2.1, 4.2, 4.4, 5.1, 5.2, 6.1	Сангийн яамны төслийн санхүүжилт, зохицуулалтын газрын(хуучнаар) түвшинд

\*Эх сурвалж: Сангийн яамны дотоод аудитын тайлан 2012

2.28. Түүнчлэн мэдээллийн сангийн нээлттэй байдал, ашиглалтын талаарх харилцаа зохицуулагдахгүй байгаа нь гадаад орон, олон улсын байгууллагаас үзүүлж буй тусламжийн мэдээг бүртгэхэд улс орнуудын бүртгэлийн систем, дотоод журам, санхүүгийн жилийн зөрөөнөөс шалтгаалан хүндрэл гарахаас гадна салбар яамдад гадаадын зээл тусламжийн асуудлыг хариуцсан нэгж нь тайланг мэдээг цаг тухайд нь авдаггүйтэй холбоотой байна. Тухайлбал:

- Япон Улсын Гадаад хэргийн яам тусламжийн мэдээ тайланг 2 жилийн сүүлд гаргадаг, санхүүгийн жил зөрдөг бөгөөд санхүүжилтийн зарцуулалтын мэдээллээ манай Сангийн яам болон салбар яамдад гаргаж өгдөггүй, харин цахим хуудсанд төслийн хэрэгжилтийн талаар тайлагнадаг.
- БНСУ нь Монголын хөгжлийн стратеги, зорилт болон Солонгосын Засгийн газраас явуулдаг “дунд хугацаатай, буцалтгүй тусламж үзүүлэх бодлого”-ын дагуу Монголын Засгийн газартай харилцан тохиролцсоны үндсэн дээр нэн тэргүүнд тусламж үзүүлэх шаардлагатай салбарыг хөтөлбөртөө тусгаж, тодорхой зорилтуудыг стратегийн гол чиглэлээ болгон, холбогдох хөтөлбөрүүдийг сонгох зарчмаар ажилладаг ч санхүүжилтийн мэдээллээ мөн гаргаж өгдөггүй байна.
- Эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах гэрээг НҮБХАС 5 жилээр, НҮБХС, ДЭМБ 2 жилээр төлөвлөсний дараа жил бүр тодотгол хийдэг бөгөөд төсөл арга хэмжээ нь дэд төслүүдэд хуваагддагаас мэдээ тайлангаа өгөхдөө дэд төслүүдээрээ өгдөг зэргээс шалтгаалан мэдээллийн зөрүүтэй байдал үүсч байна.

2.29. ГЗТЗТ хуулийн 14.1.4<sup>20</sup>, 2011 оны 86 дугаар тушаалаар батлагдсан журмын 6.2.6<sup>21</sup>, 8.2.8<sup>22</sup>-д заасны дагуу төслийн санхүүгийн тайланг улирал, хагас жил, жилээр гаргаж зээлдүүлэгчийн болон гадаадын зээл, тусламжийн асуудал хариуцсан байгууллагын холбогдох журам, зааварт нийцүүлэн валют болон төгрөгөөр тус тус бэлтгэх үүрэгтэй ч салбар яамдад тэр бүр хэрэгжилт хангалтгүй, зээл тусламжийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгадаггүй, зөрүүтэй үнээр тусгах тохиолдол нилээдгүй байна. Тухайлбал:

<sup>20</sup>14.1.4. зээл, тусламжаар нийлүүлсэн эд хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгуулах;

<sup>21</sup>6.2.6ТХБ нь төслийн санхүүгийн тайланг төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд жил бүр нэгтгэх;

<sup>22</sup>8.2.8.ТХН нь төслийн санхүүгийн тайланг улирал, хагас жил, жилээр гаргаж зээлдүүлэгчийн болон гадаадын зээл, тусламжийн асуудал хариуцсан байгууллагын холбогдох журам, зааварт нийцүүлэн валют болон төгрөгөөр тус тус бэлтгэх үүрэгтэй;

- ЭМС-3 төслийн хүрээнд өрхийн эмнэлгүүдэд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн тендерийн үнэнд тээвэрлэлт угсралтын зардлууд нь багтсан бөгөөд тэр дүнгээр тусгахаар ЭМС-ын тушаалууд гарсан байтал нийлүүлэгч талаас хүлээлгэн өгөхдөө угсралт болон тээвэрлэлтийн зардлыг нэмснээс данс бүртгэлд зөрүүтэй тусгасан, эсвэл анхан шатны баримтын бүрдэл дутуугаас данс бүтгэлдээ тусгаагүй, түүнд тавьж буй дотоод хяналт хангалтгүйгээс хөрөнгийг илүү дутуу бүртгэсэн байна.
- Эх хүүхдийн эрүүл мэнд, зүрх судас, сүрьеэ болон халдварт өвчний чиглэлээр хэрэгжсэн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр олгогдсон хөрөнгийг төслийн нэгж, бэлтгэн нийлүүлэгчээс тухайн мэргэжлийн кабинетэд хүлээлгэн өгдөг ч хүлээн авсан тухайн эмнэлгийн санхүүгийн албаны ажлын хариуцлагаас шалгаалан санхүүгийн баримтыг хүлээлгэн өгөөгүйгээс данс бүртгэлд дутуу тусгах, заримыг нь тусгаагүй байна.
- ММСС-гаас тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн ч гэрээний дагуу төсөл дууссан үед ТӨХ болон ЭМС-ын тушаалаар хөрөнгөө шилжүүлсэн учир аудитын явцад данс бүртгэлд тусгаагүй байсан

2.30. Энэ нь яамдын газар хэлтсийн ажлын уялдаа холбоо хангалтгүй, бэлтгэн нийлүүлэгч болон ажил гүйцэтгэгч байгууллагууд санхүүгийн баримтаа дутуу өгдөг, хүлээн авагч байгууллагын хамтын ажиллагаа дутмаг, зээл тусламжийн хэрэгжилтэд тавьж буй хяналт хангалтгүйтэй холбоотой байна.

2.31. Хөгжлийн албан ёсны тусламжийн үр өгөөжийг сайжруулахад дан ганц Сангийн яам төдийгүй төсөл хөтөлбөрийг хариуцан хэрэгжүүлж буй салбарын яамд, агентлаг чухал үүрэгтэй бөгөөд тодорхой салбар дахь зээл, тусламжийн ашиглалт, үр өгөөжийн талаар хяналт тавих, Сангийн яаманд үнэн зөв мэдээлэх үйл ажиллагаа харилцан адилгүй, санхүүжилтийн мэдээг хожимдуулах, орхигдуулах, нууцлах зэрэг бэрхшээл гарсаар байна.

## **Дүгнэлт**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Гадаадын зээл, тусламжийг зохицуулах хуулийн заалтын дагуу зээл, буцалтгүй тусламж хүлээн авах бодлого, стратеги чиглэлийг батлуулж, мөрдөөгүйгээс нэгдсэн бодлого алдагдсан байна.
2. Сангийн яам болон яамдын Зээл тусламжийг зохицуулах зөвлөл нь хандивлагч орон, ОУБ-ыг мэдээллээр хангах, тэдний хоорондын үйл ажиллагааг зохицуулах талаар хангалтгүй ажиллаж байна.
3. Гадаадын зээл, тусламжийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээ судалгааны үнэн зөв байдал, зээл, тусламжийн ашиглалтад тавих хяналт, төслийн үр өгөөжийг тооцох ажил үр нөлөөтэй хийгдэхгүй байна.
4. Салбарын яам болон төсөл хэрэгжүүлэх нэгж нь төсөл хэрэгжүүлэхээс өмнө судалгаа хийж, зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, биелэлтийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг нарийн тооцож боловсруулахгүй, хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход яамдын оролцоо хангалтгүй байна.
5. Сангийн яам болон салбар яамд, хэрэгжүүлэгч байгууллагаас хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн төслүүдийн хэрэгжилт, ашиглалт, үр дүнг тооцож хяналт, үнэлгээ хийж ирсэн тогтолцоо нь өнөөгийн шаардлагыг хангахгүй байна.

## **Зөвлөмж**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

### **Нэг. Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт:**

1. Хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар ойрын жилүүдэд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага, хамрах хүрээ, салбар чиглэл, зорилго, зорилтыг төрийн захиргааны байгууллагууд болон хандивлагч улс, олон улсын байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр зээл, тусламжийн бодлогоо зөв тодорхойлж, төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх дунд хугацааны бодлого, стратеги боловсруулж, зохих журмын дагуу батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулах

### **Хоёр. Сангийн сайд Ч.Улаанд**

1. Төсвийн ерөнхийлөн захирагчид, тэдгээрийн харъяа байгууллагуудад хэрэгжиж буй зээл, тусламжийн төслийн үйл ажиллагаа, ашиглалтад тавих хяналт, үнэлгээг тогтмолжуулж үр нөлөөг дээшлүүлэх, бэлтгэгдсэн хөрөнгийг үнэн зөв бүртгэж, зээл тусламжийг ашиглагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулан нягтлан бодох бүртгэлд тусгах заавар журмыг боловсронгуй болгох.
2. Зээл, тусламжийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн хөрөнгийн тооцоог төсвийн ерөнхийлөн захирагчтай хийж, данс бүртгэлд тусгаж, буруутай байгууллага, аж ахуй нэгж, албан тушаалтанд хариуцлага тооцох арга хэмжээг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх.
3. Сангийн яам болон төсвийн ерөнхийлөн захирагчдын зээл, тусламжийн мэдээллийн сангийн зөрүүтэй байдлыг тодруулж ҮАГ-т эргэж мэдээлэх



## Бүлэг 3

### Монгол Улсыг Хөгжүүлэх сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг тооцож баталгаажуулаагүй байна

#### Монгол Улсыг хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлээгүй байна

- 3.1. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн (МУХС) тухай хууль 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдөр батлагдаж, 2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж, 2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс МУХС-ийн хууль хүчингүй болж, тус сан татан буугдаж, үйл ажиллагаа нь зогссон байна.
- 3.2. МУХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хүүхдийн мөнгөн тэтгэмж, газрын тос, хүнсний улаанбуудайн нөөцийн хадгалалтын хөлс, үдийн цай хөтөлбөр, малчин иргэнд олгосон ноолуурын мөнгөний санхүүжилтийн орлогын хэмжээг 2008 онд **435,7 тэрбум** төгрөгөөр, 2009 онд **507,0 тэрбум** төгрөгөөр тус тус төлөвлөж баталсан байна.

#### 3.3. МУХС-гийн 2008-2009 оны орлогын гүйцэтгэлийг харуулбал: /тэрбум төгрөгөөр/

№	Орлогын нэр төрөл	2008 он			2009 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	463.61	384.85	(78.76)	129.66	186.53	56.87
2	Улсын төсвийн ашиг	128.61	28.60	(100.01)			
3	Эрсдлийн сангийн зарцуулагдаагүй хөрөнгө	7.65	7.65				
4	Хүүгийн орлого	0.22	0.86	0.64			
5	Бусад		3.66	3.66	3.26	4.29	1.03
	<b>ДҮН</b>	<b>600.09</b>	<b>425.62</b>	<b>(174.47)</b>	<b>132.92</b>	<b>190.82</b>	<b>57.90</b>

- 3.4. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлого 78.8 тэрбум төгрөгөөр тасарсан нь зэсийн үнэ буурснаас Эрдэнэт ХХК-ийн төсөвт төвлөрүүлэх зэсийн үнийн өсөлтийн албан татвар 37.7 тэрбум төгрөгөөр тасарсан, Алтан дорнод ХХК 38.6 тэрбум төгрөгийн алтны үнийн өсөлтийн албан татварыг төлөөгүйгээс шалтгаалжээ.
- 3.5. 2007 оны улсын төсвийн ашгаас 128.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс төсвийн хүндрэлээс шалтгаалан 100.0 тэрбум төгрөгийг санхүүжүүлээгүй байна. Харин хүүгийн орлогыг 0.6 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч төлөвлөгдөөгүй бусад орлогоос 3,7 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.
- 3.6. Иймд 2008 оны орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр нь 174,5 тэрбум төгрөгөөр тасарч, 2009 онд орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр нь 57.9 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлжээ.

**Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008-2009 оны төсвийн зарлагын зарим зардлыг хэтрүүлсэн байна.**

- 3.7. 2008 оны МУХС-гийн зарлага **435.7 тэрбум** төгрөг батлагдсанаас төсвийн тодотголоор 2.5 тэрбум төгрөг нэмэгдэж, гүйцэтгэлээр **438.2** тэрбум төгрөг зарцуулсныг хүснэгтээр харуулбал: (сая төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2008 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1 Хөрөнгө оруулалтын зардал	300,644.4	252,259.3	48,385.1
2 Хүүхдийн мөнгөн тэтгэмж	104,600.0	84,973.7	19,626.3
3 Банкны үйлчилгээний хураамж		1.3	(1.3)
4 Малчин иргэнд олгосон ноолуурын санхүүжилт	30,500.0	24,580.4	5,919.6
5 Бензиний нөөц бүрдүүлэхэд олгосон санхүүжилт		44,364.0	44,364.0
6 Үрийн буудайн санхүүжилт		32,060.1	32,060.1
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>435,744.4</b>	<b>438,238.8</b>	<b>2,494.4</b>

- 3.8. МУХС-гийн 2009 оны мөнгөн зарлага 507.0 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 481.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: (сая төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2009 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Хөрөнгө оруулалтын зардал	179,501.1	160,704.5	(18,796.6)
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	104,600.0	90,106.3	(14,493.7)
Банкны үйлчилгээний хураамж			
Малчин иргэнд олгосон ноолуурын санхүүжилт			
Газрын тосны болон хүнсний улаан буудайн нөөцийн хадгалалтын хөлс	3,298.1	5,969.2	2,671.1
Үрийн буудайн санхүүжилт	-	5,500.0	5,500.0
<b>ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>287,399.2</b>	<b>262,280.0</b>	<b>(25,119.2)</b>
Улсын төсвийн алдагдлыг нөхөхөд	219,600.0	219,600.0	-
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>506,999.2</b>	<b>481,880.0</b>	<b>(25,119.2)</b>

- 3.9. Хүснэгтээс үзэхэд хөрөнгө оруулалтын зардалд 179.5 тэрбум төгрөг батлагдсанаас 160.7 тэрбум төгрөгийн буюу 89.5 хувийн, Хүүхдийн мөнгөний хөтөлбөрөөр 104.6 тэрбум төгрөг батлагдаж 90.1 тэрбум төгрөгийн буюу 86.1 хувийн зардлыг тус тус санхүүжүүлжээ.

- 3.10. МУХС-ийн тухай хуулиар 2008 онд худалдан авч нөөцөлсөн хүнсний улаан буудайн болон газрын тосны бүтээгдэхүүний хадгалалтын зардлыг 2009 онд 3.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан боловч гүйцэтгэлээр 6.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, батлагдсан төсвийг 2.7 тэрбум төгрөгөөр хэтрүүлсэн байна.

**МУХС-гийн хөрөнгөөр худалдан авсан хүнсний улаанбуудайн үлдэгдлийг тооцоо хийж баталгаажуулаагүй байна.**

- 3.11. МУХС-ийн тухай 2007 онд батлагдсан хуулийн 6.5-д “Энэ хуулийн 6.1.1-д заасан хөрөнгийг мөнгөн болон гурил, улаанбуудай, бензин шатахууны нөөц хэлбэрээр байршуулж болох бөгөөд Засгийн газар энэ тухай саналаа холбогдох тооцоо, судалгааны хамт УИХ-д өргөн мэдүүлж шийдвэрлүүлнэ.” гэж заасан байна.

- 3.12. “МУХС-гийн хөрөнгийн зарим хэсгийг хүнсний улаанбуудайн нөөц хэлбэрээр байршуулах тухай” УИХ-ын 2008 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 42,

